



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 05 сарын 01 өдөр

Дугаар А/201

Мандсговь

Г Шагнаж, урамшуулах тухай Т

Монгол Улсын "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай" хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 /а/, Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.1.4, Засаг даргын 2017 оны А/407 дугаар захирамжаар батлагдсан "Шилдэг төрийн албан хаагч шалгаруулж, урамшуулах журам"-ын 4.3 дэх заалт, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.3 дахь заалт, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2018 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 07 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. 2018 оны аймгийн "Шилдэг төрийн албан хаагч"-аар нэр бүхий 2 сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтэнг журмын дагуу шалгаруулж тус бүр өргөмжлөл 1,000,000 төгрөгөөр шагнаж урамшуулсугай.

Хоёр. Шилдэг төрийн албан хаагчаар шалгарсан сувилагч, тусгай мэргэжилтэн нарын нэрсийг 1 дүгээр, урамшууллын зардлыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

Гурав. Шагналын зардалд шаардагдах 2.112.000 /Хоёр сая нэг зуун арван хоёр мянга / төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн ЗДТГазар /Ц.Эрдэнэсүрэн/, нягтлан бодогч /Г.Мөнхбаясгалан / нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



О. БАТ-ЭРДЭНЭ

0226580

Аймгийн Засаг даргын 2018 оны 05 дүгээр сарын
01-ний өдрийн *А/201* тоот захирамжийн 1 дүгээр хавсралт



"Шилдэг төрийн албан хаагч"-аар шалгарсан сувилагч, тусгай
мэргэжилтэн нарын нэрс

№	Овог нэр	Албан тушаал
1	Гомбосүрэн Алдармаа	Нэгдсэн эмнэлэгийн яаралтай тусламжийн сувилагч
2	Норов Мөнхцэцэг	Нэгдсэн эмнэлэгийн төрөх тасгийн нярайн сувилагч



Аймгийн Засаг даргын 2018 оны 05 дүгээр сарын
01-ний өдрийн /2018/ тоот захирамжийн 2 дугаар хавсралт

"Шилдэг төрийн албан хаагч" нарыг урамшуулах, урамшууллын зардал

№	Зардлын утга	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Бүгд үнэ
1	Урамшуулал	2	1000000	2,000,000
2	Хүндэт өргөмжлөл	2	50000	100,000
3	Батламж	2	6000	12000
	ДҮН			2,112,000

